



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 28 өдөр

Дугаар А/687

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээ
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.2, 38.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаал, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит бус XVII хуралдааны 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээгээ шилжүүлэх хүсэлт гаргасан “Хөвсгөл ус суваг” ХХК (РД:4140265)-ын 3 нэгж талбарын нийт 0.2136 (2136м²) газрыг хавсралтаар тус тус шилжүүлэн эзэмшүүлсүгэй.


2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа хуулийн этгээдтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзул)-д тус тус зөвшөөрсүгэй.

3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

4. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.


5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭГ БУСДАД ШИЛЖҮҮЛСЭН АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСАЛТ



Аймгийн Засаг даргын 2023 оны
12 дугаар сарын 28-ны өдрийн
А/68.7-дүгээр захирамжийн хавсралт

№	Эрх шилжүүлж байгаа аж ахуйн нэгжийн нэр, регистр	Эрх шилжүүлэн авч байгаа аж ахуйн нэгжийн нэр, регистр	Нэгж талбарын дугаар	Газрын зориулалт	Газрын байршил, хаяг	Газрын хэмжээ /м2/	Газар эзэмшүүлэх хугацаа	Хүчингүй болгож буй захирамжийн дугаар	Тайлбар
1	"Хөвсгөл ус суваг" ХХК (Р.Д.4140265)	"Хөвсгөл дулааны станц" ТӨХК (Р.Д.4139992)	6712017101	Дэд бүтцийн байгууллага	7-р баг Далайван-4 429 тоот	1106	22	Аймгийн Засаг даргын 2020.10.30-ны өдрийн А/561 дүгээр захирамжийн хавсралтын 10 дахь заалт	Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит бүс ХҮИ хуралдааны 09 дүгээр тогтоолын хавсралтын 3, 13, 14 дэх заалтуудаар шилжүүлэх шийдвэрийн дагуу
2	"Хөвсгөл ус суваг" ХХК (Р.Д.4140265)	"Хөвсгөл дулааны станц" ТӨХК (Р.Д.4139992)	6712015757	Дэд бүтцийн байгууллага	8-р баг Дамдинбазар-4 423 тоот	319	13	Аймгийн Засаг даргын 2020.02.10-ны өдрийн А/64 дүгээр захирамжийн хавсралтын 11 дэх заалт	
3	"Хөвсгөл ус суваг" ХХК (Р.Д.4140265)	"Хөвсгөл дулааны станц" ТӨХК (Р.Д.4139992)	6712016410	Дэд бүтцийн байгууллага	8-р баг Даваадорж-2 214 тоот	711	22	Аймгийн Засаг даргын 2021.01.25-ны өдрийн А/38 дугаар захирамжийн хавсралтын 4 дэх заалт	

Нийт газрын хэмжээ: 2136м²

000